



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 316

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Тогтвортой амьжиргаа төсөл-3" төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 18,090,910.00 (арван найман сая ерэн мянга есөн зуун арав) төгрөгийн балансын үнэ, 15,980,303.83 (арван таван сая есөн зуун наян мянга гурван зуун гурван төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий сервер компьютерыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Тогтвортой амьжиргаа-3 төслийн захирал Г.Золбоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132001557

16-r huraldaan.docx